

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: Ард Кредит ББСБ ХК УБГД: 9010002003 ҮЦК: ADB Утас: +976 77003322
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк бус санхүүгийн байгууллага
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Нексия Глобал Монголиа аудит ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	364,000,000 (гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Г.Есү-Үжин Хянасан: Гүйцэтгэх захирал: Г.СҮХБААТАР

1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт (мянган төгрөг)	Эхний үлдэгдэл (1-р сарын 1)	Эцсийн үлдэгдэл (12-р сарын 31)
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	89,645,968.05	108,495,904.23
	Эргэлтийн бус хөрөнгө	25,852,260.67	8,256,636.31
	Нийт хөрөнгө	115,498,228.71	116,752,540.54
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Өр төлбөрийн нийт дүн	78,523,225.61	76,308,173.71

		Эздийн өмч	36,975,003.10	40,444,366.83
		Нийт өр төлбөр ба эздийн өмч	115,498,228.71	116,752,540.54
	Орлогын тайлан	Үзүүлэлт (мянган төгрөг)	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
		Хүүгийн орлого	18,609,009.00	21,679,501.15
		Хүүгийн зардал	(8,773,235.00)	(12,826,116.78)
		Цэвэр хүүгийн орлого	9,835,774.00	8,853,384.37
		Хүүгийн бус орлого	6,276,635.00	8,452,340.76
		Хүүгийн бус зардал	(9,125,485.00)	(8,136,884.67)
		Болзошгүй эрсдэлийн зардал	(2,856,452.00)	(7,637,939.74)
		Үндсэн бус үйл ажиллагааны орлого	577,219.00	3,529,444.06
		Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(276,093.00)	(983,918.34)
		Татварын өмнөх ашиг	4,431,598.00	4,076,426.44
		Орлогын татварын зардал	(497,206.00)	(583,172.18)
		Цэвэр ашиг	3,934,392.00	3,493,254.27
1.1.	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>			
	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон компанийн санхүүгийн тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу Нексия Глобал Монголиа аудит ХХК хөндлөнгийн аудит хийж, эерэг дүгнэлт өгсөн.			
1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>			



Нексия Глобал Монголиа Аудит ХХК
Энхбасси Уян Биолдинг, 606 тоот, 6-р давхар,
Звөнгийн гудамж, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар, Монгол Улс

Утас: +976 7700 1500
Вэб хаяг: www.nexia.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Аудиторын дүгнэлт

Бид Ард Кредит ББСБ ХК (цаашид "Компани" гэх)—ийн 2025 оны 12 дугаар сарын 31—ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31—ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"—ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)—ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.


Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"—ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:


Э.БУЛГАН
Партнер

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр


2

Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, уридлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан мэдээлэл

2.1.

Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

Үйл ажиллагааны ашгийн хувь	14.8%
Цэвэр ашгийн хувь	10.5%

		Өөрийн хөрөнгийн өгөөж	9.0%
		Нийт хөрөнгийн өгөөж	3.0%
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 17.3% Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа (D/E) 1.6	
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	1. Компанийн засаглалын кодексын хэрэгжүүлэгч ТОП-20-ээр дахин шалгарав.   2. Монголын Банк бус санхүүгийн байгууллагын холбооны Санхүүгийн хүртээмжтэй шилдэг ББСБ-аар тодров. 3. БНХАУ-ын Ханжоу хотод зохион байгуулагдсан “Maker in China” SME Innovation & Entrepreneurship Global Contest-д амжилттай оролцож, олон улсын шилдэг стартапуудтай өрсөлдөн “Black Horse Award” шагналын эзэн боллоо.  4. Барилгын фасад, дээвэр, шилэнд нэгтгэгдсэн нарны эрчим хүч үйлдвэрлэх BIPV Mongolia компанитай хамтын ажиллагаанд санамж бичиг зурж, ногоон зээлийн хүсэлтийг Ард Аппаар дамжуулан авдаг болов. 	
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Тэнцлийн гадуур дансанд хүлээж болзошгүй үүрэг хариуцлага, эрсдэлийн сангаас хаасан тооцоо, зээлийн барьцааны эд зүйлс, үнэ бүхий зүйлс ангилалаар бүртгэдэг. Тухайн тайланд хугацаанд тэнцлийн гадуур зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийн дүн 584.6 сая төгрөг, хуримтлуулж тооцохыг зогсоосон зээл 425.7 сая төгрөг байна.	
2.5.	Тайлан хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд 148.6 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн төлөлт хийлгэв.	
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлан хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/		

Их хэмжээний хэлцэл:
2025 онд их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:
Компанийн тухай хууль болон Ард Кредит ББСБ ХК-ийн Нэгдмэл Сонирхолтой этгээдтэй гэрээ байгуулах дүнгээс үл хамааран Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдэд танилцуулан тухай бүр Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчил зохицуулах журамд нийцүүлэн шийдвэрлэдэг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2025 онд 23 сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг олгосон байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдийн хэлцэлд хяналт тавин ажиллаж байна.

Мөн Ард Кредит ББСБ ХК-ийн хувьд Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын дагуу шалгуур үзүүлэлтийг хангаж, улирал бүр тайлангаа хүргүүлэн ажиллаж байгаа болно.

Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээллийг хөндлөнгийн аудитын “Холбоотой талууд” хэсэгт тогтмол нийтэд мэдээллэдэг болно.

4. Цалин урамшууллын мэдээлэл

ТУЗ-ийн цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүдийн урамшууллыг тогтоохдоо компанийн тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот гүйцэтгэлийн хувь болон гишүүн тус бүрийн оролцоо, гүйцэтгэлийг харгалзан жилд нэг удаа олгодог. ТУЗ-ийн жилийн төсөв, цалин урамшууллын хэмжээг ТУЗ өөрөө баталдаг зохицуулалттай байсан бөгөөд 2025 онд Компанийн дүрэмд ТУЗ-ийн жилийн төсөв, цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар өөрчлөлт оруулсан.

ТУЗ-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэл болон 2026 оны төсвийг доорх хүснэгтээр харуулав.

ТУЗ-ийн төсөв	2025 он /Төгрөг/		2026 он /Төгрөг/
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв
Цалин	123,780,000	123,780,000	123,780,000
Урамшуулал	55,890,000	55,890,000	55,890,000
Сургалт, хурлын зардал	13,500,000	13,500,000	13,500,000
	193,170,000	193,170,000	193,170,000

Гүйцэтгэх удирдлагын урамшуулал

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж байна. Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг тогтоохдоо Санхүүгийн болон санхүүгийн үзүүлэлтүүдийн биелэлт, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг харгалзан үзэж, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон Цалин, урамшууллын хорооноос зөвлөмж гаргаж, ТУЗ-ийн хурлаар хорооны зөвлөмжийг хэлэлцэн гүйцэтгэх удирдлагын урамшууллыг олгох эсэх шийдвэрийг гаргадаг.


	Компанийн ТУЗ-ийн 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 2026/10 тоот тогтоолоор Гүйцэтгэх захирлын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж, холбогдох урамшууллыг олгохоор шийдвэрлэсэн болно.
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа

Ард Кредит ББСБ ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана.

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 6 ердийн гишүүн 3 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй сонгогдсон ба Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн Гүйцэтгэх захирал, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Комплаенс хариуцсан мэргэжилтэн, Дотоод аудиторыг тус тус томилон ажиллуулж байна.

Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан стратеги төлөвлөгөө, үүрэг даалгаврын биелэлтийг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн компанийн засаглалыг бэхжүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор зохион байгуулалтын бүтцийг оновчтой тодорхойлон баталж, хяналт тавьж ажиллав.



Хувьцаа эзэмшигчдийн хурал

Ард Кредит ББСБ ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд компанийн стратеги, бодлого, томоохон шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн оролцоотойгоор хэлэлцэн шийдвэрлэдэг. Хувьцаа эзэмшигчид нь ээлжит болон ээлжит бус хурлаар дамжуулан санал өгөх, асуулт тавих, мэдээлэл авах, удирдлагын тайлантай танилцах зэргээр өөрсдийн хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байна.

Компани нь 2025 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг Компанийн тухай хууль болон холбогдох журамд бүрэн нийцүүлэн зохион байгуулж, хувьцаа эзэмшигчдийн оролцоог нээлттэй, тэгш, хүртээмжтэй байдлаар хангаж ажиллалаа.

Хурлыг зохион байгуулахдаа мэдээллийг тухай бүр ил тод хүргэх, хэлэлцэх асуудлаар дэлгэрэнгүй танилцуулга өгөх, санал асуулгын процессыг ойлгомжтой, шударга байдлаар явуулахад онцгой анхаарч, хувьцаа эзэмшигчдийн идэвхтэй оролцоог дэмжин ажилласан нь компанийн засаглалын хариуцлагатай, нээлттэй соёлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Сэнтрал Тауэр-ийн 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд журмын дагуу амжилттай зохион байгуулагдлаа.

Хуралд 298,723,332 ширхэг буюу нийт саналын эрх бүхий хувьцааны 83 хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчид оролцож, дараах асуудлуудыг хэлэлцсэн юм.

Хурлаар танилцуулсан асуудал:

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
- Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
- ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг танилцуулах;
- Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

Хурлаас гарсан шийдвэр:

Хурлаас Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг 100 хувийн саналаар, компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг мөн 100 хувийн саналаар дэмжин тус тус баталж шийдвэрлэлээ.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 14:00 цагт цахим хэлбэрээр журмын дагуу амжилттай зохион байгуулагдлаа.

Тус хуралд саналын эрх бүхий 299,569,334 ширхэг буюу нийт саналын эрх бүхий хувьцааны 83.03 хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчид оролцож, хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн юм.

Хурлаар танилцуулсан асуудал:

- Компанийн албан ёсны бүртгэлтэй хаягийг өөрчлөх;
- Компанийн үйл ажиллагааны чиглэлд Факторингийн үйлчилгээг нэмэх;
- Үйл ажиллагааны чиглэл нэмэх, албан ёсны хаягийг өөрчилсөнтэй холбогдуулан Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөл оруулах.

Хурлаас гарсан шийдвэр:

Хурлын санал хураалтын дүнд Компанийн албан ёсны хаягийг Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Энхтайвны өргөн чөлөө, 17 дугаартай барилгын 9 дүгээр давхар болгон өөрчлөх асуудлыг, Үйл ажиллагааны чиглэлд факторингийн үйлчилгээ нэмэх асуудлыг 98 хувийн саналаар дэмжиж, компанийн дүрэмд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлэлээ.

Ээлжит бус хурлын шийдвэрүүд нь компанийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, стратегийн хөгжлийг дэмжих, засаглалын баримт бичгийг бодит нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэхэд чиглэсэн чухал алхам боллоо.

Төлөөлөн удирдах зөвлөл



ТУЗ-ийн дарга
Ч. Ганзориг
Цалин, урамшууллын хорооны гишүүн



Ердийн гишүүн
О. Одбаяр
Санхүү, зосдал, зээлийн хорооны дарга



Хараат бус гишүүн
В. Ганзориг
Дотоод аудитын хорооны дарга



Ердийн гишүүн
Г. Уянга
Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүн



Ердийн гишүүн
Б. Золбоо
Засаглал, нэр дэвшүүлэх болон Санхүү, зосдал, зээлийн хорооны гишүүн



Хараат бус гишүүн
С. Энхчимэг
Цалин, урамшууллын хорооны дарга, Дотоод аудитын хорооны гишүүн



Ердийн гишүүн
Г. Сүхбаатар
Санхүү, зосдал, зээлийн хорооны гишүүн



Ердийн гишүүн
М. Мөнх-Эрдэнэ
Дотоод аудитын хорооны гишүүн



Хараат бус гишүүн
Б. Солонго
Засаглал, нэр дэвшүүлэх хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны гишүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэргэшил, ажлын туршлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй компанийн цахим хуудасны ТУЗ хэсгээс танилцах боломжтой

ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан

ТУЗ нь 2025 онд компанийн урт хугацааны стратеги, тогтвортой өсөлт, эрсдэлийн удирдлага, засаглалын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх хороод тогтмол хуралдаж, бүрэн эрхийн хүрээнд ээлжит хурал 4 удаа, ээлжит бус хурал 1 удаа хуралдаж, эцнээ санал хураалт 46 удаа явуулан нийт 63 тогтоол баталж, нээлттэй компаниас олон нийтэд мэдээлэл хүргэх тухай журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлж ажиллав.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Санхүү, зээл, эрсдэлийн хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Дотоод аудитын хороодтойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Санхүү, зээл, эрсдэлийн хороо

ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, зээл, эрсдэлийн хороо нь компанийн санхүүгийн тогтвортой байдал, зээлийн бодлого, эрсдэлийн удирдлагын стратегийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэлээ.

Тус хороо нь компанийн стратеги төлөвлөгөөг судалгаанд суурилан боловсруулж ТУЗ-д танилцуулан батлуулах, компанийн үнэлгээ болон хувьцааны үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэх бодлогын санал боловсруулах, зээл олголт болон багцын чанарт хяналт тавих, зээлийн саналуудыг бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэх чиглэлээр ажиллалаа.

2025 онд тус хороо ээлжит 4 удаа, ээлжит бус 1 удаа, эцнээ санал хураалт 10 удаа зохион байгуулж, компанийн зээлийн бодлого, эрсдэлийн удирдлагын хүрээнд шаардлагатай шийдвэрүүдийг тухай бүр гаргасан байна.

Хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр, гишүүдээр Б.Золбоо, Г.Сүхбаатар нар ажиллалаа.

Дотоод аудитын хороо

Дотоод аудитын хороо нь санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа нь батлагдсан төсөв, төлөвлөгөө болон олон улсын стандартын шаардлагад нийцэж буй эсэхэд хараат бус дүгнэлт өгөх, дотоод аудит, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөнд хяналт тавих, хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулах, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэв.

Тайлант онд тус хороо ээлжит 4 удаа, ээлжит бус 1 удаа зохион байгуулж, санхүүгийн тайлагнал, дотоод хяналтын тогтолцооны үр ашигт байдалд хяналт тавин ажиллаж байна.

Хорооны даргаар хараат бус гишүүн В.Ганзориг, гишүүдээр С.Энхчимэг, М.Мөнх-Эрдэнэ нар ажиллаж байна.

Засаглал, нэр дэвшүүлэх хороо

Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга болон гүйцэтгэх удирдлагыг нэр дэвшүүлэх, тэдгээрийг үнэлэх шалгуур, журмыг боловсруулж хэрэгжүүлэх, ТУЗ-ийн гишүүдийн оролцоо, идэвх, хараат бус гишүүдийн хараат бус байдлыг

үнэлэх, залгамж халааны бодлогыг боловсруулж ТУЗ-өөр батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүллээ.

2025 онд тус хороо ээлжит хурал 3 удаа, ээлжит бус 1 удаа, эчнээ санал хураалт 2 удаагийн явуулж, засаглалын бодлого, хүний нөөцийн залгамж халааны төлөвлөлтийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Хорооны даргаар хараат бус гишүүн Б.Солонго, гишүүдээр Г.Уянга, Б.Золбоо нар ажиллаж байна.

Цалин урамшууллын хороо

Цалин, урамшууллын хороо нь гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын бодлогыг компанийн гүйцэтгэл, стратегийн зорилттой уялдуулан боловсруулах, үнэлэх, ТУЗ-д санал оруулах чиг үүргийг хэрэгжүүлэв.

2025 онд тус хороо 1 удаагийн ээлжит хурал, 2 удаагийн цахим санал хураалт зохион байгуулж, гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээ болон урамшууллын бодлогын хэрэгжилтийг хэлэлцэв.

Хорооны даргаар хараат бус гишүүн С.Энхчимэг, гишүүдээр Ч.Ганзориг, Б.Солонго нар ажиллаж байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн хурлын ирц, үнэлгээ

ТУЗ	ТУЗ-ийн гишүүн	Компанийн хувьцаа эзэмшдэг эсэх	2025 оны ээлжит болон ээлжит бус хурлын ирц/ эчнээ санал хураалтад оролцсон идэвхи
ТУЗ-ийн дарга	Ч.Ганзориг	0.19%	100%
Ердийн гишүүн	О.Одбаяр	0.01.%	100%
Ердийн гишүүн	Б.Золбоо	0.11%	100%
Ердийн гишүүн	Г.Уянга	0.0.9%	97%
Ердийн гишүүн	Г.Сүхбаатар	0.07%	100%
Ердийн гишүүн	М.Мөнх-Эрдэнэ	0.05%	100%
Хараат бус гишүүн	В.Ганзориг	0.03%	100%
Хараат бус гишүүн	Б.Солонго	0.01%	96.20%
Хараат бус гишүүн	С.Энхчимэг	Үгүй	100%

ТУЗ-ийн гишүүд нь Компанийн дүрэм болон үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хараат бус, хариуцлагатай зарчмыг баримтлан ажиллаж байна. Шийдвэр

гаргах үйл ажиллагаа нь Компанийн тухай хуулийн дагуу олонхын саналаар баталгааждаг. Тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдийн хурлын ирц болон цахим санал хураалтын оролцоо дунджаар 96 хувиас дээш байсан нь засаглалын хэм хэмжээг чанд сахиж, хүлээсэн үүрэг хариуцлагаа өндөр түвшинд хэрэгжүүлж буйн илэрхийлэл юм

Компанийн Засаглалын Кодекс хэрэгжилт, түүний үнэлгээ

Ард Кредит ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Бирж-ийн I ангилалд бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон олон улсын сайн туршлагад нийцсэн засаглалын тогтолцоог төлөвшүүлэх, тасралтгүй сайжруулахыг стратегийн зорилтынхоо салшгүй хэсэг болгон ажиллаж байна.


Түүнчлэн компанийн засаглалын тогтолцоог сайжруулах хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороо-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан Компанийн засаглалын кодекс-ийг үйл ажиллагааны зарчим болгон баримтлан тасралтгүй хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус кодексийн хэрэгжилтийг бид 98.6 хувиар үнэлэн (СЗХ-оос хянан баталгаажаагүй байгаа болно), олон нийтэд тайлагнасан билээ. “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд хүрсэн нь компанийн засаглалын бодлого, хяналтын тогтолцоо үр дүнтэй хэрэгжиж байгааг илтгэж байна.

Цаашид бид засаглалын ил тод байдал, хараат бус байдал, хариуцлагын тогтолцоог улам боловсронгуй болгож, олон улсын шилдэг туршлагыг үе шаттайгаар нэвтрүүлэх замаар тогтвортой өсөлт, урт хугацааны үнэ цэнийг бий болгоход чиглэн тууштай ажиллах болно.


№	Агуулга	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6
5	Эрсдэлийн удирдлага	8	8
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8
8	Компанийн соёл	6	6
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10

	Хэрэгжилт	72	71									
6.	Эрсдэлийн удирдлагын мэдээлэл											
	Ард Кредит ББСБ ХК нь ТУЗ-с баталсан Эрсдэлийн удирдлагын бодлогоор 8 төрлийн эрсдэл тодорхойлж эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлагын соёлыг төлөвшүүлэн ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд ТУЗ ба ТУЗ-ийн дэргэдэх хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Үүнд: 1. Дотоод аудитын хороо; 2. Санхүү, зээл, эрсдэлийн хороо; 3. Засаглал, нэр дэвшүүлэх, 4. Цалин урамшууллын хороо. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж гүйцэтгэх удирдлагад хяналт тавьж ажиллаж байна. Эрсдэлийн засаглал нь хамгаалалтын гурван бүсийн дараах чиг үүрэгтэй. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО Хамгаалалтын 3 бүсийн хүрээнд байх ба дараах байдлаар байна. ТУЗ / Аудитын хороо Гүйцэтгэх удирдлага Хамгаалалтын I бүс Хамгаалалтын II бүс Хамгаалалтын III бүс											
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/											
	Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 14,261-д хүрч олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноос хойш жил бүр Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс болон I ангилалд багтаж ирсэн уламжлалт амжилтаа хадгаллаа. 2024 оны туршид 1.1 тэрбум төгрөгийн 10.4 сая ширхэг компанийн хувьцаа Монголын хөрөнгийн биржээр арилжаалагджээ. <table><tr><th>Нэр</th><th>Тоо ширхэг</th><th>Хувь</th></tr><tr><td>Ард Санхүүгийн Нэгдэл ХК</td><td>144,449,917</td><td>39.70%</td></tr><tr><td>Ардын Тэтгэврийн Данс ХХК</td><td>28,128,478</td><td>7.70%</td></tr></table>			Нэр	Тоо ширхэг	Хувь	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	144,449,917	39.70%	Ардын Тэтгэврийн Данс ХХК	28,128,478	7.70%
Нэр	Тоо ширхэг	Хувь										
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	144,449,917	39.70%										
Ардын Тэтгэврийн Данс ХХК	28,128,478	7.70%										

	<table><tr><td>С. Гэрэлтуяа</td><td>27,305,402</td><td>7.50%</td></tr><tr><td>Ард Лизинг ХХК</td><td>19,057,550</td><td>5.20%</td></tr><tr><td>Х. Батхишиг</td><td>14,426,999</td><td>4.00%</td></tr><tr><td>С. Орпил</td><td>13,994,296</td><td>3.80%</td></tr><tr><td>Мост Финтек ХХК</td><td>10,785,009</td><td>3.00%</td></tr><tr><td>Г. Бат-Эрдэнэ</td><td>10,719,260</td><td>2.90%</td></tr><tr><td>Ард Секюритиз УЦК ХХК</td><td>9,139,837</td><td>2.50%</td></tr><tr><td>Ц. Батбилэг</td><td>7,000,000</td><td>1.90%</td></tr><tr><td>Олон нийт</td><td>78,993,252</td><td>21.70%</td></tr><tr><td>Нийт</td><td>364,000,000</td><td>100.00%</td></tr></table>	С. Гэрэлтуяа	27,305,402	7.50%	Ард Лизинг ХХК	19,057,550	5.20%	Х. Батхишиг	14,426,999	4.00%	С. Орпил	13,994,296	3.80%	Мост Финтек ХХК	10,785,009	3.00%	Г. Бат-Эрдэнэ	10,719,260	2.90%	Ард Секюритиз УЦК ХХК	9,139,837	2.50%	Ц. Батбилэг	7,000,000	1.90%	Олон нийт	78,993,252	21.70%	Нийт	364,000,000	100.00%	Хувьцаа эзэмшлийн бүтцийн пай диаграмм 
С. Гэрэлтуяа	27,305,402	7.50%																														
Ард Лизинг ХХК	19,057,550	5.20%																														
Х. Батхишиг	14,426,999	4.00%																														
С. Орпил	13,994,296	3.80%																														
Мост Финтек ХХК	10,785,009	3.00%																														
Г. Бат-Эрдэнэ	10,719,260	2.90%																														
Ард Секюритиз УЦК ХХК	9,139,837	2.50%																														
Ц. Батбилэг	7,000,000	1.90%																														
Олон нийт	78,993,252	21.70%																														
Нийт	364,000,000	100.00%																														
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																															
	Компанийн 2024 онд олон нийтэд нээлттэй гаргасан 13.5 тэрбум төгрөгийн бондын хүүгийн төлөлтүүдийг хуваарийн дагуу төлөв.																															
9.	Ногдол ашигийн мэдээлэл																															
	Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 сарын 11 өдрийн ТУЗ-ийн 2025/10 тоот тогтоолоор компанийн цаашдын өсөлтийг дэмжих зорилгоор 2024 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв. 2026 оны 02 сарын 16-ны өдрийн 2026/5 тоот тогтоолоор компанийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 3.04 (гурав зууны дөрөв) төгрөг буюу цэвэр ашгийн дүнгээс 1,106,560,000 (нэг тэрбум нэг зуун зургаан сая таван зуун жаран мянга) төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 сарын 07-ны өдрөөр тогтоосон ба 2026 оны 4 сарын 30-ны өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд шилжүүлнэ.																															
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл																															
	Ардын Альфа 2025 урамшуулалт хөтөлбөрийг зохион байгуулж санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэв.																															

- Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2025 орон нутгийн аймаг, сумдад Ард Аппын цогц үйлчилгээ, Зээл, санхүүгийн шийдлийг иргэдэд шууд хүргэж, санхүүгийн мэдлэг, хандлагыг сайжруулахад чиглэсэн ажлыг хэрэгжүүлэв.
- Монгол Улсын тэргүүлэгч байгууллагуудын нэг болох Монгол Шуудан ХК-тай ухаалаг ПОС (Point of Sale) системийг ашиглан Монгол орны бүх аймаг, сумдад санхүүгийн үйлчилгээг хүргэх дэд бүтцийг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.
- Технологи бизнесийн Smart Software Summit 2025 арга хэмжээнд хамтрагч байгууллагаар оролцож, компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулав.
- Монголын шинэ үеийн инженерүүдийн мэдлэг боловсрол, технологийн салбарын хөгжлийн төлөө, залуусыг дэмжих, нийгмийн хариуцлагын хүрээнд MEF Youth 2025, DevSummit 2025 | The AI Generation арга хэмжээнд ивээн тэтгэгч, хамтрагчаар оролцов.

АРД АППААР ОЛГОСОН ОНЛАЙН ЗЭЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД
ҮЗҮҮЛЭХ ЗЭРЭГ НӨЛӨӨ



Үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлснээр

Нийт цаас хэмнэлт: 80.53 тонн

Хэмнэсэн мод: 1,677.7 ширхэг

Хэмнэсэн цаг: 116.23 жил (буюу 1,018,154 цаг)

Зорчилт бууруулалт: 509,077 удаа

Эрчим хүчний хэмнэлт: 311,973.87 кВт.ц

CO2 ялгарлын бууралт: 1,404,857.50

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Гүйцэтгэх захирал Г.Өүхбаатар

Санхүү эрхэлсэн захирал Э.Баттуяа

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Есү-Үжин

Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгий дарга

Гарын үсэг:

АРД КРЕДИТ ББСБ ХК

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2025	2024
Хүү болон түүнтэй адилтгах орлого	5	21,679,501	18,609,009
Хүү болон түүнтэй адилтгах зардал	6	(12,826,117)	(8,773,235)
Санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэний бууралт	7	(7,637,940)	(2,713,834)
Нийт ашиг		1,215,444	7,121,940
Шимтгэл, хураамжийн орлого	8	4,120,717	3,719,545
Шимтгэл, хураамжийн зардал	9	(1,352,439)	(988,768)
Цэвэр шимтгэл, хураамжийн орлого		2,768,278	2,730,777
Ерөнхий ба удирдлагын зардал	12	(7,054,209)	(7,155,288)
Бусад орлого	10	3,455,660	1,708,047
Бусад зардал	11	(484,699)	(267,410)
Бусад олз/ (гарз)	13	4,405,408	165,510
Гадаад валютын ханшийн зөрүүний олз / (гарз)		(229,456)	128,021
Татварын өмнөх ашиг		4,076,426	4,431,597
Орлогын албан татварын зардал	14	(583,172)	(497,206)
Тайлант жилийн ашиг		3,493,254	3,934,391
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого:			
Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн өөрчлөлт		(1,400,190)	6,690,064
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг		2,093,064	10,624,455

АРД КРЕДИТ ББСБ ХК

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2025-12-31	2024-12-31
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	15	7,134,680	7,086,018
Бусдад олгосон зээл	16	66,188,370	68,112,669
Бусад санхүүгийн хөрөнгө	17	28,105,755	6,627,523
Бусад санхүүгийн бус хөрөнгө	18	5,655,607	5,166,904
Хөрөнгө оруулалт	19	7,067,099	7,819,759
Үндсэн хөрөнгө	20	472,582	512,313
Биет бус хөрөнгө	22	1,842,315	19,122,441
Ашиглах эрхтэй хөрөнгө	21	273,406	604,397
Хойшлогдсон татварын хөрөнгө		12,727	446,205
Нийт хөрөнгө		116,752,541	115,498,229
Өр төлбөр			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	23	32,418,081	33,352,630
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	24	19,315,972	19,641,858
Бусад эх үүсвэр	25	13,501,794	13,434,392
Бусад санхүүгийн өр төлбөр	26	7,715,235	7,300,547
Бусад санхүүгийн бус өр төлбөр	27	2,328,654	2,826,995
Түрээсийн өр төлбөр	21	254,597	591,277
Татвар, НДШ-ийн өглөг	28	365,503	523,970
Хойшлогдсон татварын өр төлбөр		408,338	851,557
Нийт өр төлбөр		76,308,174	78,523,226
Эздийн өмч			
Энгийн хувьцаа	29	5,023,200	3,640,000
Бусад өмч	30	5,000,000	5,000,000
Халаасны хувьцаа	29	(32,226)	(32,226)
Нэмж төлөгдсөн капитал	29	12,440,333	12,440,333
Дахин үнэлгээний нэмэгдэл	32	1,095,352	3,497,276
Бусад нөөц	31	133,000	-
Хуримтлагдсан ашиг		16,784,708	12,429,620
Нийт эздийн өмч		40,444,367	36,975,003
Нийт өр төлбөр болон эздийн өмч		116,752,541	115,498,229

АРД КРЕДИТ ББСБ ХК

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Нэмэгдэж төлсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Өмчийн бусад хэсэг	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,800,000	(58)	5,352,792	(3,084,389)	5,000,000	-	10,836,505	20,904,850
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдааны залруулга	-	58	-	-	-	-	-	58
2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	2,800,000	-	5,352,792	(3,084,389)	5,000,000	-	10,836,505	20,904,908
Тайлант жилийн ашиг	(32,226)	-	-	-	-	-	3,934,391	3,902,165
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	6,690,064	-	-	-	6,690,064
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(2,474,163)	(2,474,163)
Эздийн өмчийн өөрчлөлт	840,000	-	7,087,541	(28,125)	-	-	28,125	7,927,541
Хэрэгжсэн дахин үнэлгээний дүн	-	-	-	(80,274)	-	-	104,762	24,488
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,607,774	-	12,440,333	3,497,276	5,000,000	-	12,429,620	36,975,003
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдааны залруулга	32,226	(32,226)	-	-	-	-	(6,900)	(6,900)
2025 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	3,640,000	(32,226)	12,440,333	3,497,276	5,000,000	-	12,422,720	36,968,103
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	-	3,493,254	3,493,254
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(1,400,190)	-	-	-	(1,400,190)
Нөөц санд шилжүүлэлт	-	-	-	-	-	133,000	(133,000)	-
Эздийн өмчийн өөрчлөлт	1,383,200	-	-	-	-	-	-	1,383,200
Хэрэгжсэн дахин үнэлгээний дүн	-	-	-	(1,001,734)	-	-	1,001,734	-
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,023,200	12,440,333	(32,226)	1,095,352	5,000,000	133,000	16,784,708	40,444,367